

Манай хуулийн фирм өмнөх нийтлэлээрээ 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон батлагдсан тогтоол, шийдвэрийн талаар танилцуулсан билээ.

Энэхүү нийтлэлд тусгасан зарим хууль эрх зүйн мэдээлэл нь албан ёсны эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд хараахан нийтлэгдээгүй байгаа тул эцэслэн нийтлэгдэхдээ агуулга, найруулгын хувьд тодорхой хэмжээнд өөрчлөгдсөн байх боломжтойг анхаарна уу.

Нийтлэлд багтсан мэдээллийг Улсын Их Хурлын цахим системд “батлагдсан” төлөвтэй харагдаж буй шинээр боловсруулсан хуулийн төслүүд болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Улсын Их Хурлын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар, Засгийн газар, холбогдох яамд, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүд, сайд нарын нийтэд мэдээлсэн мэдээлэлд үндэслэн бэлтгэсэн болно.

I. ХЭЛЭЛЦЭГДСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулган нь 7 дугаар сарын 03-ны өдөр өндөрлөсөн бөгөөд чуулганаар батлагдсан онцлох хуулийн төслүүдийг танилцуулъя.

1.1 Татварын багц хуулийн төсөл

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлаас 6 дугаар сарын 26-ны өдөр эцэслэн баталсан. Татварын багц хуулиудын нэмэлт, өөрчлөлт нь иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, татварын дарамтыг бууруулах зорилготой ба эдгээрээс дурдвал:

(i) Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлт

Татварын ерөнхий хуульд оруулсан нэмэлт 63.2-р зүйлийн дагуу өртэй татвар төлөгчийн банкин дахь дансанд ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар гаргуулах татварын өрийн хэмжээ нь тухайн орлогын 80 хувиас хэтрэхгүй байхаар зохицуулжээ. Ингэснээр орлогын 20%-г нь үлдээж, үйл ажиллагаагаа тодорхой хэмжээнд үргэлжлүүлэх боломжтой байхаар өөрчилсөн.

Мөн Иргэний хуультай уялдуулан Татварын ерөнхий хуулийн 73-р зүйлд 73.4, 73.5 дахь хэсгийг шинээр нэмсэн. Эдгээр зохицуулалтын дагуу татварын хяналт шалгалтын томилолт олгосноос өдрөөс тухайн шалгалтын шийдвэр гарах хүртэл хугацаанд төлөөгүй татварт алданги тооцохгүй байхаар тусгасан. Түүнчлэн алдангийн нийт хэмжээ нь хугацаандаа төлөөгүй татварын дүн, эсхүл татварын албанаас үндэслэлгүйгээр илүү хураасан татварын дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарласан байна.

Үүнээс гадна татвар төлөгч татварын тайлангаа залруулах боломжтой хугацааг сунгасан. Тухайлбал, Татварын ерөнхий хуулийн 31.1 дэх хэсэгт заасан тайлан залруулах хугацаа өмнө нь дараагийн татварын жилээр хязгаарлагдаж байсан бол уг хугацааг дараагийн хоёр татварын жил болгон сунгажээ.

(ii) Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт

Иргэн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд ажилтанд олгох цалин хөлсөд ногдох татварын хэмжээг дараах байдлаар бууруулсан.

Хэрэгжиж эхлэх огноо	Цалин, хөлс	Татварын хэмжээ
2027.01.01	792'000 төгрөг хүртэл	0%
	792,000 төгрөгөөс дээш	10%
2028.01.01	792'000 төгрөг хүртэл	0%
	792'000-аас 2 сая төгрөг хүртэл	1%
	2 сая төгрөгөөс дээш	10%

Мөн орон сууцжуулалтыг дэмжих зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх хэсэгт албан татвараас чөлөөлөх орлогын төрлийг нэмжээ. Монгол Улсын иргэн өөрийн үндсэн оршин суух хаягт бүртгэлтэй, амьдран суух зориулалттай орон сууцаа үргэлжилсэн таваас доошгүй жилийн хугацаанд өмчилсөн бол тухайн орон сууцыг борлуулж олсон орлогыг албан татвараас чөлөөлөхөөр зохицуулсан байна. Ингэснээр 2027 оноос эхлэн дээрх шаардлагыг хангасан орон сууц борлуулсны орлогод өмнө нь ногдуулдаг байсан 2 хувийн албан татварыг чөлөөлөхөөр байна.

(iii) Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

ААНОАТХ-н 22.5-р зүйл албан татварын хөнгөлөлт үзүүлэх орлогод “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг” нэмж оруулсан байна.

Мөн ААНОАТХ-н 20.1-р зүйлд зааснаар өмнө нь 6 тэрбум төгрөгөөс дээш гарсан татвар ногдох орлогод 25 хувиар нэмж татвар ногдуулдаг байсан бол тус хувь хэмжээг бууруулах, 6-10 тэрбум төгрөгийн орлого гэх дунд шатлалыг нэмж, дараах нэмэлт, өөрчлөлт орсон.

Хэрэгжиж эхлэх огноо	Татвар ногдох орлогын хэмжээ	Ногдуулах татварын хэмжээ
2027 оны 1 дүгээр сарын 01	6 тэрбум төгрөг хүртэл	10%
	6-10 тэрбум төгрөг хүртэл	6 тэрбум төгрөг хүртэл хэсэгт 10% буюу 600 сая төгрөг
		6 тэрбум төгрөгөөс дээш давсан хэсэгт 15%
	10 тэрбум төгрөгөөс их	6 тэрбум төгрөг хүртэл хэсэгт 10% буюу 600 сая төгрөг
		6 тэрбум төгрөгөөс дээш давсан 10 тэрбум төгрөг хүртэл хэсэгт 15% буюу 600 сая төгрөг
		10 тэрбум төгрөгөөс дээш давсан хэсэгт 25%

Мөн ААНОАТХ-н 22.1-р зүйлийн өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлсөн 10 хувийн татварын 90 хувийг буцаан олгох хөнгөлөлтийн татвар ногдох орлогын босго нь 1.5 тэрбум төгрөг хүртэл байсан бол 2.5 тэрбум төгрөг хүртэл болон нэмэгдсэн байна.

(iv) Онцгой албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

ОАТХ-н 6-р зүйлд оруулсан өөрчлөлтөөр янжуур тамхи болон түүнтэй адилтгах бусад тамхи, дүнсэн тамхи болон түүнтэй адилтгах задгай тамхинд импортын гаалийн үнээс 30%-н татвар ногдуулахаар болсон байна. Энэ хэсэгт хамрын тамхийг салгаж зохицуулсан ба хамрын тамхинд 20%-н татвар ногдуулахаар болсон байна.

(v) Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журмын санал

Татварын багц хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан Татварын албанаас “Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулж байгаа бөгөөд 8 дугаар сарын 06-ныг хүртэл тус журамд татвар төлөгчдийн саналыг цахимаар хүлээн авч байна.

1.2 Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 7 дугаар сарын 02-ны өдөр эцэслэн баталжээ. Гол өөрчлөлтүүдийг дараах байдлаар хураангуйлав:

Зохицуулалт	Хураангуй тайлбар
Олон гэрээтэй ажилтан /7 дугаар зүйл/	Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон адилтгах хэд хэдэн гэрээтэй бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээг сонгон албан журмаар даатгуулна.
Үндсэн ажил + нэмэлт ажил /7.4/	Хөдөлмөрийн гэрээтэй ажилтан нэмэлт гэрээгээр ажилласан бол уг нэмэлт орлогод заавал нийгмийн даатгал төлөхгүй байж болно.
Ажил олгогчийн шимтгэлийн дээд хязгаар /19.4-19.7/	Ажил олгогчийн шимтгэл тооцох цалин хөлсний сан болон түүнтэй адилтгах орлогод дээд хязгаар тогтооно.
Жижиг ажил олгогчийн хөнгөлөлт /21 дүгээр зүйл/	5-аас ихгүй ажилтантай ажил олгогчийн 3 хүртэл ажилтны ажил олгогчоос төлөх зарим шимтгэлийг 36 сар хүртэл чөлөөлнө. Төрийн болон орон нутгийн өмчит, гадаад улсын, олон улсын байгууллага, ТББ-д хамаарахгүй.
Анх удаа даатгуулагч /7.7/	Өмнө нь нийгмийн даатгалд хамрагдаж байгаагүй иргэний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг 24 сар хүртэл чөлөөлнө.

1.3 Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль

Тус хуулийн төсөл нь УИХ-н чуулганаар 7 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан. Тус хууль нь хувийн өмч, гэрээний эрх чөлөө, шударга өрсөлдөөн, хөрөнгө оруулалт болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтвортой орчныг хамгаалах зорилготой.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг Улсын Их Хурлын чуулганаар 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан байна. Тус хууль нь хувийн өмчийн эрх, гэрээний эрх чөлөө, шударга өрсөлдөөн, хөрөнгө оруулалт болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтвортой орчныг хамгаалахад чиглэжээ.

Хуулийн анхны төсөлд эдийн засгийн эрх чөлөөний зарчимд нийцээгүй хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөхгүй байхаар тусгасан байсан бол батлагдсан хувилбарт бусад хууль тогтоомжийг тус хуулийн эдийн засгийн эрх чөлөөний зарчимд нийцүүлэх агуулгаар зөөлрүүлэн найруулсан байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлд аж ахуй эрхлэгч хуулиар хориглоогүй үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, эдийн засгийн харилцаанд эрх тэгш оролцох эрхийг баталгаажуулжээ. Харин 11.4 дэх хэсэгт Монгол Улс олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтад үндэслэлгүй саад тавихгүй бөгөөд хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалахаар зохицуулсан байна.

Иймд тус хууль нь Монголын болон гадаадын хөрөнгө оруулагчдад илүү тогтвортой бизнесийн орчин бүрдүүлэх, төрийн үндэслэлгүй оролцоог хязгаарлах, аж ахуй эрхлэгчийн эрхийг хамгаалах ач холбогдолтой гэж үзэж болно. Мөн эдийн засгийн эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн аж ахуй эрхлэгч холбогдох байгууллага, шүүхэд хандан эрхээ хамгаалуулах боломжтой.

1.4 Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг дагалдуулан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуулийн төслүүдийг баталжээ. Тус нэмэлт, өөрчлөлтөөр болон өмнөх хэсэгт дурдсанчлан гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх татвар дэмжлэг, урамшуулал болон гадаадын хөрөнгө оруулагчдад ямар боломж үүсэж байгаа танилцуулъя.

(i) Татварын дэмжлэг, хөнгөлөлт

Гадаадын байгууллагын өрийн хэрэгслийн хүүгийн орлогод ногдуулах суутган төлөх татварын хувь хэмжээ 20% байсныг 5% болгон бууруулсан байна. Ийнхүү гадаадын хөрөнгө оруулагчдад орох орлогын татвар буурсны үр дүнд хөрөнгө оруулагчдын орлого өөрчлөгдсөн татварын хэмжээний зөрүү болох 15%-р нэмэгдэх юм.

Харин дата болон хиймэл оюун ухааны төвийн мэдээллийн технологийн зориулалттай тоног төхөөрөмжийн импортын барааны гаалийн албан татварыг хөнгөлөхөөр болсон. Ингэснээр мэдээлэл технологийн чиглэлээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа болон ирээдүйд үйл ажиллагаа явуулах байгууллагуудын зардал буурах, цаашлаад тус тоног төхөөрөмжийг экспортлох байгууллагуудын борлуулалт нэмэгдэх боломжтой юм.

(ii) Маргаан шийдвэрлэлт

Мөн аливаа маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа 6 сарын дотор үр дүнд хүрэхгүй бол хөрөнгө оруулагч тухайн маргааныг үндэсний эсхүл олон улсын арбитра шилжүүлэх боломжтой болж, хөрөнгө оруулагчид маргаанаа олон улсын арбитраар шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан.

Үүний сацуу Хөрөнгө оруулалт, худалдааны газар хөрөнгө оруулагчдын гомдлыг хүлээн авч, холбогдох төрийн байгууллагууд руу зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн гүйцэтгэлийн тайлан авч, хөрөнгийн оруулагчдын эрхийг хангаж ажиллах болсон байна.

(iii) Гадаадын банкны салбар байгуулахад тавигдах шаардлага

Түүнчлэн Монгол улсад Гадаадын банк салбараа байгуулах нөхцөлд Монгол Улсын банкны салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 20%-тай тэнцэх хэмжээний хөрөнгөтэй байх шаардлагыг халсан байна.

Ингэснээр өндөр босго шаардлагыг давж чадахгүй байсан олон улсын банк, санхүүгийн байгууллагууд Монголын зах зээлд нэвтрэх боломжтой болох бөгөөд үүнийг даган өрсөлдөөн бий болж, Монголын банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа сайжрах нөхцөл бүрдэх юм. Үүний үр дүнд хэрэглэгчдийн үйлчилгээ авах банк болон авах үйлчилгээний тоо олширч, илүү өндөр хүүтэй хадгаламжинд мөнгөө хадгалах, нөхцөл, шаардлага, хүү багатай зээл авах гэх мэт боломжууд үүсч магадгүй юм.

1.5 Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн зорилго нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн, хүлэмжийн хийн тэг ялгаралд хүргэхэд чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн механизм, карбон зах зээлийг хөгжүүлэх, хүлэмжийн хийн тооллого, хэмжилт,

тайлагнал, баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсгүүдэд тус тус зааснаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засаг, нийгмийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн, хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв, мөнгөний бодлого, ногоон санхүүжилтийн стратегитай нийцсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг ногоон санхүүжилтээр дэмжих юм.

Үүнд "ногоон санхүүжилт" гэж байгаль орчны тогтвортой хөгжлийн хүрээнд байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлэх, доройтлыг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжихэд чиглэсэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд нийцсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хэлэх юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагалдуудан олон хуульд нэмэлт, өөрчлөлт орсон ба эдгээрээс бизнес эрхлэгчдэд хэрэг болохуйц зарим өөрчлөлтүүдээс танилцуулъя.

(i) Авто замын тухай хуулийн өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль батлагдсантай холбогдон Авто замын тухай хуульд дараах өөрчлөлт орсон байна.

Хуучин зохицуулалт	Шинэ зохицуулалт
Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид авто замын салбарын бүтээн байгуулалтад хөрөнгө оруулахыг төрөөс дэмжинэ.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид авто замын салбарын бүтээн байгуулалтад зам тээврийн салбарт хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инноваци, үйлдвэрлэлийн арга нэвтрүүлэхийг төрөөс дэмжинэ.

(ii) Тариалангийн тухай хуулийн өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль батлагдсантай холбогдон Тариалангийн тухай хуульд дараах өөрчлөлт орсон байна.

Хуучин зохицуулалт	Шинэ зохицуулалт
Тариалангийн тухай хуулийн 14.2.1-д заасан газрыг тариалангийн эргэлтэд оруулах зорилгоор хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээ авсан бол төрөөс дэмжлэг	Тариалангийн тухай хуулийн 14.2.1-д заасан газрыг тариалангийн эргэлтэд оруулах, газар тариалангийн салбарт нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инноваци, үйлдвэрлэлийн аргыг нэвтрүүлэх

үзүүлж болно.	зорилгоор хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээ авсан бол төрөөс дэмжлэг үзүүлж болно.
---------------	--

1.6 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт

Сүүлийн үед мопед, скүүтер зэрэг тээврийн хэрэгслүүдтэй холбоотой асуудлууд ихэссэн. Үүнд Замын хөдөлгөөний дүрэм мөрдөхгүй байх, насанд хүрээгүй хүүхдүүд жолоодох зэрэг асуудлууд багтана.

Тэгвэл Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан мопед, скүүтер зэрэг тээврийн хэрэгслийг нарийвчлан тодорхойлж, нийтийн хэрэгцээний үйлчилгээг зохицуулсан байна.

Тус хуулийн дагуу мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл (нийтлэлд цаашид "мопед, скүүтер" хэмээн товчлох болно)-ийн жолооч нь тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байх ба мопед, скүүтер эзэмшигч нь тээврийн хэрэгслийг бүртгүүлж байх шаардлагатай болсон байна.

(i) Зөрчлийн тухай хуулийн нэмэлт

Дээрх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд дараах нэмэлтийг оруулсан байна. Үүнд:

- 1) Мопед, скүүтерийг жолоодож явган хүний гарцаар зам хөндлөн гарсан бол хүнийг тавин мянган төгрөгөөр;
- 2) Мопед, скүүтерийг жолоодон замын хөдөлгөөнд оролцсон арван найман нас хүрээгүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хоёр зуун мянган төгрөгөөр;
- 3) Нийтийн хэрэгцээний мопед, скүүтерийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд өөрийн эзэмшлийн мопед, мопед, скүүтерийг бүртгүүлээгүй, арван найман нас хүрээгүй хүүхэд болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14.2-т заасан сургалтад хамрагдаагүй хүнийг мопед, скүүтер жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол таван зуун мянган төгрөгөөр;
- 4) Нийтийн хэрэгцээний мопед, скүүтерийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс тогтоосон зогсоолын байршлаас бусад нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбай, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол, ногоон байгууламж, нийтийн зориулалттай орон

сууцны байшингийн орчны газрын ногоон зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, эдгээртэй адилтгах газарт тээврийн хэрэгслээ байршуулсан бол тавин мянган төгрөгөөр тус тус торгох нэмэлтүүдийг оруулсан байна.

Мөн Замын хөдөлгөөний дүрмийн дагуу унадаг дугуй, мопед, скүүтер нь замын хөдөлгөөд оролцохдоо унадаг дугуйн зам буюу унадаг дугуйн эгнээгээр явах бөгөөд тийм зам, эгнээ байхгүй эсхүл түүгээр явах боломжгүй тохиолдолд зорчих хэсгийн баруун гар талын захаар байрлан явах юм.

II. УЛСЫН ИХ ХУРАЛ: ОНЦЛОХ ТОГТООЛ

2.1 Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай тогтоол

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт алтны олборлолтыг нэмэгдүүлэх, алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, уул уурхайн салбарын экспортын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх

зорилтыг тусгасан. Үүнтэй холбоотой алтны ордуудыг эргэлтэд оруулах нь экспортын орлого, гадаад валютын улсын нөөц, төсвийн орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой болохыг танилцуулан тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлжээ.

Тус төслийн хэрэгжилтийн үр дүнд жил бүр Монгол банкинд нийт 5 тонн орчим алт тушаах, экспортын болон татварын орлого, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засаг, ажлын байр, Үндэсний баялгийн сангийн орлогод эерэг нөлөө үзүүлэхээр байна.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж, Centrum
Office, 3 давхар, 301/a
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8058-0414